



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний үеийн  
тусламж, үйлчилгээний зохион  
байгуулалтыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Эрүүл Мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Томуу томуу төст өвчний үеийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг эрчимжүүлэх тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган ТУШААХ нь:

1. Томуу томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, зохион байгуулалтын арга хэмжээг сайжруулах чиглэлээр хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Чанарын менежер (Д.Дашдэлэг)-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналтын ажилтан (Г.Гантуяа)-д даалгасугай.

ДАРГА



Х.ГАНБАТ